



**ХЭНТИЙ АЙМГИЙН
МӨРӨН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 09 сарын 16 өдөр

Дугаар А/130

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 59 дүгээр зүйлийн 59.1.1, Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.5 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Мөрөн сум үүсгэн байгуулагдсаны 101 жилийн ойн баяр наадмын зардалд зориулан 1 619 000 (нэг сая зургаан зуун арван есөн мянган) төгрөгийг зарцуулсугай.

2 Шаардагдах зардлыг Засаг даргын нөөц хөрөнгийн зардлаас гаргахыг нягтлан бодогч (Б.Нандин-Эрдэнэ)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА

Ц.БАТЦООЖ

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ХАМТ

ОЛНЫ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ.

№ 04

2024он 09 сарын 16

Хурал 2024 оны 09 сарын 16 ны өдрийн 14 цагт Засаг даргын өрөөнд 80% ирцтэй хурал эхлэв.

ХЭЛЦЭХ АСУУДАЛ:

Мөрөн сум үүсгэн байгуулагдсаны 101 жилийн ойн их баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэх зардал гаргах талаар

СОНССОН НЬ:

Ц.Батцоож: Та бүхэндээ энэ өдрийн мэнд хүргэе. Мөрөн сум үүсгэн байгуулагдсаны түүхт 101 жилийн ойн их баяр наадмын зардалд 1619000 /нэг сая зургаан зуун арван есөн мянга / төгрөгийн зардал гаргах тул Та бүхэн минь санал бодлоо хэлэлцье.

Н.Намжилноров: Сумын түүхт 101 жилийн баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэх зардал мөнгө хаанаас гарах вэ.

Ж.Дашжамц: Хэдэн төгрөг болж байгаа нь яг тодорхой юу хаанаас гархаа ярилцаад явах уу

Ж.Галтуяа : Засаг даргын Нөөцөөс гарах боломжтой юу

Б.Мягмаржав: наадмын зардал мөнгө хэдэн төгрөг болхыг тооцож гаргасан уу

Намжилноров: За Засаг даргын нөөц хөрөнгөөс
гарах саналтай байна.

Б.Нандин-Эрдэнэ зардалыг тооцож үзсэн

Ц.Батцоож: Миний хувьд зардлыг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргая гэсэн бодолтой байна.Засаг даргын нөөц хөрөнгийн зардлыг Засаг даргын тамгын газрын хамт олны хурлаар хэлэлцүүлж зарцуулах журамтай тул та бүхэн хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Г.Энхцэцэг за Засаг даргын нөөцөөс гаргах саналыг зөвшөөрч байна уу саналыг хараад шийдвэр гаргах уу

Ж.Дашжамц: Засаг даргын нөөц хөрөнгөөс холбогдох зардлыг гаргах нь зөв байх.

Бусад гишүүд бүгд санал нийлж байна уу

С.Энхсүх өнөөдрийн Засаг даргын тамгын газрын хамт олны хурлаар Мөрөн сум 101 жилийн ойн их баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлхэд гарах зардлын талаар хуралдаж байнаа ингээд наадмын зардлыг Засаг даргын нөөцөөс гарах санал 100 хувь дэмжиж байгаа тул уг зардлыг ЗДТГ-ын нөөц хөрөнгөөс гарах шийдвэр гарч байна гэж ойлгож байна.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Засаг даргын тамгын газрын хамт олны хуралд оруулсан Наадмын зардлыг Засаг даргын нөөцөөс гаргах санал 100% ийн саналаар дэмжигдэн 1.619.000 төгрөгийн зардлыг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахаар шийдвэрлэв

ТЭМДЭГЭЛ ХӨТӨЛСӨН:

Жс.

Г.ЭНХЦЭЦЭГ